

Ц.Уугангэрэл, Б.Өнөрбаяр, Б.Баярбилэг, Ч.Болдбаатар А.Дүүрэнбилэг, Т.Эрхэмбаатар

## ТӨРӨХ ҮЕИЙН УРАГ ОРЧМЫН ШИНГЭНИЙ БӨГЛӨРӨЛ

**Эмнэл зүйн тохиолдлын танилцуулга:** Үйлчлүүлэгч эх Г. Нийслэлийн Өргөө Амаржих Газрын Жирэмсэний Эмгэгийг Эмчлэх Тасагт 2021 оны 03 сарын 19-нд ХУД-ийн 9-р хороонд оршин суух 02732 тоот өвчний түүхтэй 37 настай эмэгтэй дөрөв дэх жирэмслэлт 39/40 долоо хоногтой жирэмсэн, манас таталтын урьдал хөнгөн хэлбэр, том ураг оноштойгоор хэвтсэн. Асуумжинд 3 удаа төрөх замаар хэвийн төрсөн, энэ удаагийн жирэмслэлт нь сүүлийн саруудад хавагнаж, АД ихсэж байсан. Төрөх эмнэлэгт хэвтсэнээс хойш 4 хоногийн дараа буюу 2021 оны 03 сарын 23-нд умайн хүзүүг эмээр бэлтгэж төрөх замаар төрүүлэх шийдвэр гаргаж улмаар төрөлтийг сэдээх зорилгоор 25 мг мезопростолийг үтрээний арын хүнхрээнд тавьсан. Төрөх үйл ажиллагаа эхэлснээс хойш 6 цагийн дараа ураг орчмын шингэний хальсыг хагалсан.

Ураг орчмын шингэний (УОШ) хальсыг хагалснаас хойш 15 минутын дараа буюу 2021 оны 03 сарын 24-ний өглөө 09 цаг 15 минутанд эмэгтэйд дотор муухайрах, давчдах, цээжээр өвдөх, хөндүүрлэх зовиур илэрч тайван биш болж нүүр царай хөхөрч эхэлсэн. Богино хугацаанд эмэгтэйд хагалгааны өрөөнд тээвэрлэж улмаар тусламж үзүүлэх баг дуудсан. Хэдхэн минутын дотор жирэмсэн эмэгтэйн ухаан санаа бүүдгэрч, нүүр хөхөрч, арьс эрээнтэж таталт өгсөн. АД 73/34 мм.муб, зүрхний цохилт 1 минутанд 45 удаа, амьсгал 1 минутанд 6 удаа, SpO<sub>2</sub>-77% болсон. УЗЦ 1 минутанд 100 удаа. УОШ бөглөрөл гэж үзэн эхийн амь насыг аврах зорилгоор кесар мэс заслаар төрүүлэхээр шийдвэрлэсэн.

Гүрээний өнгөц венийн судас болон 2 гарын венийн судсанд 16G, болон 18G уян зүү тавьж Адерналин 0.5мг судсаар хийж 100% хүчилтөгрөгчтэй маскаар амьсгалуулж булчин бүрэн сулармагч цагаан мөгөөрсөн хоолойд интубаци гуурс тавьж ерөнхий мэдээгүйжүүлэг хийсэн. Минутын дараа 4050 кг жинтэй, 53 см охин Апгарын 1/3/4 баллтай төрсөн. Хүүхэд төрсний дараа умай агшилтгүй болж цус их хэмжээгээр алдаж улмаар цус бүлэгнэлтийн өөрчлөлт илэрсэн тул умайг умайн хүзүү, 2 талын дайварын хамт бүхэлд нь авах мэс засал хийсэн. Мэс заслын үед гемодинамик тогтворжуулах, цусны бүлэгнэлт засах, алдсан цусыг нөхөх зорилгоор ижил бүлгийн цус цусан бүтээгдэхүүн их хэмжээгэр сэлбэж, улмаар вазопрессор болон инотроп эмчилгээнүүд хавсран хийгдсэн.

Кесар мэс засал дууссаны дараа төрсөн эхийг эрчимт эмчилгээний тасагт шилжүүлж амьсгалын аппаратад холбож шаардлагатай эмчилгээнүүдийг үргэлжлүүлэн хийж байсан ба мэс засал дууссаад 6 цагийн дараа хэвлийн хөндийд цус алдалт үргэлжилж байгаа нь хэт авиан шинжилгээгээр оношлогдсон учир дахин яаралтай ерөнхий унтуулгатай давтан мэс засалд орж бүлэгнэлтийн системийн өөрчлөлтөөс шалтгаалан шархны талбайгаас цус шүүрч, алдаж байсан тул цус тогтоох оёдлууд дахин тавигдсан.

Давтан мэс засал хийлгэснээс хойш эрчимт эмчилгээний тасагт УОШ бөглөрөл, Амьсгал-зүрх судасны дутагдал, Судсан дахь цус түгмэл бүлэгнэх хам шинж, Тархины гипоксийн комын байдал 3-р зэрэг гэсэн оноштой найм хоног амьсгалын аппаратад байсан боловч амьсгал сэргэхгүй, ухамсарт ухаангүй, рефлексүүд сэргэхгүй цаашид удаан

## Нийслэлийн Өргөө амаржих газар

хугацаанд амьсгалын аппарат шаардлагатай болсон тул байнгын трахеостоми хийгдсэн. Улмаар эмчилгээний явцад үжил, үжлийн хатгалгаа, амьсгал дутагдал III зэргээр хүндэрч эмчлэгдсэн.

Мэдрэлийн эмчийн зөвөлгөөний дагуу нейропротектор, антиневротик, тархины нейроцеркуляци дэмжих эмчилгээнүүд, мөн хоёрдогч хүндрэлээс сэргийлэх, сэргээн засах физик эмчилгээ болон уйгагүй асаргаа сувилгааны үр дүнд биеийн байдал өдрөөс өдөрт аажмаар сайжирч асуулт ойлгож, команд биелүүлж ганц нэг үгээр ярьдаг болсон төдийгүй хөдөлгөөн сэргэж хүний дэмжлэгтэй алхаж явж чаддаг болсон хэдий ч нүдний хараа сул, өнгө ялгах чадвар муу, ой санамж сул зэрэг тархины хүчилтөрөгчийн дутагдлын дараах хөнгөн хэлбэрийн тархины эмгэгшилтэй үлдсэн. Эрчимт эмчилгээний тасагт 43 хоног эмчлэгдсэн ба эмнэлгээс гарахаас өмнө трахеостомийн гуурсыг авсан.

Тухайн үйлчлүүлэгчийн НӨАГ-т хэвтсэн ор хоног 48, нийт эмчилгээний зардал 13.354.509.08 (арван гурван сая, гурван зуун, тавин дөрвөн мянга таван зуун есөн төгрөг нойл найман мөнгө). Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ болон эх барихын зөвлөх эмчийн үзлэг 10, эмч нарын хамтарсан үзлэг 6, мэдрэлийн эмчийн зөвөлгөө тусламж 7, чих хамар хоолойн эмчийн тусламж үйлчилгээ 4 удаа тус тус авахын зэрэгцээ сэтгэц, нүд, уушгины эмчийн үзлэг, зөвөлгөө тус бүр нэг удаа хийгдсэн байна.



Шинэ мэдлэг дундын өмч